



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 17/257

Мандалговь

Г  
Өлзийт сумын жишиг гудамж талбайн дэд бүтэц,  
тохижилтын ажлын зураг, төсөв хүлээн авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Өлзийт сумын жишиг гудамж талбайн дэд бүтэц, тохижилтын ажил”-ын зураг, төсөв хүлээн авах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга)

О.Цолмон (Цолмон арт ХХК-ийн захирал)

Б.Буманбаатар (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн мэргэжилтэн)

2. Өлзийт сумын жишиг гудамж талбайн дэд бүтэц, тохижилтын ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
*И.Доржбат* Л.ДОРЖБАТ

4912150623